



ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

2013 оны Санхүүгийн Тайлан

Үндэсний Аудитын Газрын харьяа Төв аймгийн Аудитын газар нь Төрийн Аудитын тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим холбогдох хууль, журам зааварт нийцүүлэн аудит хийж байна.

Лавлах зүйлс байвал доорх хаягаар холбоо барина уу:

Дарга, Тэргүүлэх Аудитор
Л.Жаргалсайхан
Утас: 70272582
И-мэйл: Jargalsaikhan_tuv@yahoo.com
Аудитын менежер
О.Амаржаргал
Утас: 70273204
И-мэйл: amraa_tuv@yahoo.com
Шинжээч
Ц.Хишигжаргал
Утас: 70273204
И-мэйл: khj_616@yahoo.com

Хаяг:

Төв аймаг Зуунмод сум 1-р баг
Төрийн байгууллагуудын ордон

Аудитыг дуусгавар болгосон тухай тайлан

АГУУЛГА

ХУУДАС

• Танилцуулга	4
• Санхүүгийн дотоод хяналт	4-10
• Гол шийдлүүд	10
• Залруулаагүй алдаа	11
• Тайлбар мэдүүлгийн захидал.....	11
• Аудитын санал дүгнэлт	11

Аймгийн ЗДТГ сумын 2013 оны Санхүүгийн Тайланд

аудит хийж дууссан тухай мэдэгдэл

Бид Аймгийн ЗДТГазрын 2013 оны Санхүүгийн тайланд аудитаа хийж дуусаж байна. Аймгийн ЗДТГазрын төсвийн Ерөнхий менежерт энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаарх бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд Аймгийн ЗДТГазар тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.

Удирлагын зөвлөлийн анхаарлыг дараах зүйлд чиглүүлж байна:

Гол санхүүгийн хяналтууд хамрагдсаныг **тодруулбал:**

НББ-ийн үе шат бүрд дээд шатны түвшний удирдлага хүрдэг эсэх, нийтлэг чанартай зардал, төсвийн санхүүжилт, өөрийн орлого, цалингийн зардал, өглөг, авлага, балансын үзүүлэлтүүд, үндсэн хөрөнгө, бараа материал, бусад асуудлуудыг хамруулсан бөгөөд байж болзошгүй эрсдлийг тооцож холбогдох батламж мэдэгдлүүд хэрхэн хангагдаж байгааг нотлох үүднээс холбогдох стандарт, журам зааврын дагуу шаардлагатай горимыг хэрэгжүүлсэн.

- Гол илрүүлсэн зүйлс аудитын үр дүнгээс гарсныг **тодруулбал:**
- 2013 оны санхүүжилтээс 53251.7 мянган төгрөг төсөвт буцаан татагдсанаас үзэхэд өр барагдуулахад нэмж олгосон 16620.8 мянган төгрөгийн төсвийн тодотгол хийлгэж, нэмэлт санхүүжилт авах шаардлагагүй байжээ.
- Данснаас хасагдсан хөрөнгөнд аймгийн ИТХурлын Тэргүүлэгчдийн 2013.10.15-ны өдрийн 95 дугаар тогтоол гарч аймгийн ЗДТГазраас 457840.0 мянган төгрөгний барилга байгууламжийг худалдахаар, 34880.6 мянган төгрөгний тоног төхөөрөмжийг актлахаар, 12665.1 мянган төгрөгний тавилга, хэрэгслийг актлахаар тус тус шийдвэрлэсэн боловч, барилга тогтоолд заасан хэмжээнээс 51489.7 мянган төгрөгөөр, тоног төхөөрөмж 406.9 мянган төгрөгөөр тус тус илүү, аж ахуйн тавилга, хэрэгсэл 54.7 мянган төгрөгөөр дутуу данснаас хасч, тогтоолын заалт зөрчигдсөн байна.
- Худалдсан орон сууцнуудын үнээс 365547.4 мянган төгрөгийг төвлөрүүлээгүй байна.
- ЗДТГазрын дарга нь ЗДТГазрын “Хөдөлмөрийн дотоод журам”-ын заалтыг үндэслэн гэж 2013.5.24-нд а/36 тоот тушаал гарган ажилтнуудынхаа хүүхдүүдэд “Эх үрсийн баяр”-ын бэлэгэнд 1049.2 мянган төгрөг, 2013.03.06 –нд а/24 тоот тушаалаар Эмэгтэйчүүдийн баярт 1028.8 мянган төгрөг тус тус зарцуулах шийдвэр гаргаж 2078.0 мянган төгрөгийг

2013 оны Санхүүгийн тайлан

ЗДТГазрын төсвөөс зарцуулсан байгаад төлбөрийн акт бичив.

- Анхан шатны баримтын нөхөлт дутуу, гарын үсгийн бүрдэл дутуу байгаа нь “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”-ийн 7.5. Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно.7.6. Анхан шатны баримтын бүрдэлт, үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна гэсэн хуулийн заалт зөрчигдсөн байна.
- МУЗГазрын 2008.12.24-ны өдрийн 67 тоот тогтоолоор батлагдсан Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг шинэчлэн тогтоох тухай шийдвэр хүчингүй болоогүй бүтэц зохион байгуулалт нь өөрчлөгдөөгүй байхад Аймгийн ЗДТГазрын ХБХэлтсийн даргаар ажиллаж байсан Д.Чулуунбатад 4508.9 мянган төгрөгийн тэтгэмж үндэслэлгүйгээр олгож төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Ерөнхий менежер болон санхүүгийн албанаас Аймгийн Аудитын Газар тайлбар мэдүүлэг хүлээж байгаа

-Илэрсэн алдааг хэрхэн залруулах талаар тайлбар ирүүлнэ үү

Аудитыг дуусгаж аудитын явцад олж авсан ажлын баримтанд болон аудитын газарт ирүүлсэн тайлбарыг үндэслэн, дээрх зөрчлүүд материалагын урьдчилан тогтоосон түвшингээс бага байгаа тул **зөрчилгүй** дүгнэлт гаргуулахаар Тэргүүлэх аудиторт санал оруулсан байгаа

Тэргүүлэх Аудитор 2014.04.10-ний өдөр санал дүгнэлтэнд гарын үсэг зурна.

Эцэст нь аудитын явцад бидэнтэй хамтран ажилласанд гүнээ талархаж байна.

ҮАГХТААГазар 2014.04.08

Танилцуулга

1. Бид Аймгийн ЗДТГазрын 2013 оны 12 дугаар сарын 31-р тасалбар болсон санхүүгийн тайланд аудитаа хийж дуусаж байгаа ба ЗДТГазрын даргад энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаар бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд Аймгийн ЗДТГазар тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.
2. Бидний 2013 онд тайланд хийсэн аудит нь 2 гол элементтэй:
 - Санхүүгийн хяналтын системийг дахин шалгах;
 - Жилийн санхүүгийн тайланд аудит хийх.Аудитнаас үүдэн гарсан асуудлууд дараах хэсэгт хураангуйлагдсан.

Жилийн санхүүгийн тайланд аудит хийх.

3. ААГ санхүүгийн хяналтыг дахин шалгаж үзээд санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг баталгаажуулах шаардлагатайг авч үзсэн. Бидний дахин шалгалт нь цаг ямагт үр өгөөжтэй материаллаг алдаанаас сэргийлж чадах гол санхүүгийн хяналтыг онцгойлон үзсэн юм. Бид Аймгийн ЗДТГазрын даргад тухайн жилийн эдгээр хяналтын асуудлын тухай тайлагнасан.
4. Дараахь түвшний хяналтын асуудал бидний дахин шалгалтын үр дүнгээс гарсан бөгөөд үүнд Аймгийн ЗДТГазрын удирдлагын анхаарлыг хандуулж байна:

1. Орлого санхүүжилтийн талаар

Аймгийн ЗДТГазар нь орон нутгийн төсвөөс 1036396.7 мянган төгрөгийн санхүүжилт, аймгийн Засаг даргын а/681 тоот захирамжаар өр барагдуулах гэж 16620.8 мянган төгрөг, үндсэн бус үйл ажиллагааны орлого 1818.3 мянган төгрөг, эрх зүйн туслалцааны төвийн санхүүжилт 358.7 мянган төгрөг нийт 1055194.5 мянган төгрөгийн эх үүсвэртэйгээр тайлагнасан байна.

Архивын лавлагааны орлого 17909.7 мянган төгрөг, Үндэсний Архивын газраас 35717.3 мянган төгрөгийн санхүүжилт авч нийт 53627.0 мянган төгрөгийн эх үүсвэртэй байна.

Тайлант онд 1027118.0 мянган төгрөгний үндсэн хөрөнгө, 19228.3 мянган төгрөгний бараа материал үнэ төлбөргүй авч, үйл ажиллагааны мөнгөн орлого 1108821.5 мянган төгрөгийн хамт нийт 2155167.8 мянган төгрөгний орлого, эх үүсвэр тайлагнасан байна. 2013 оны санхүүжилтээс 53251.7 мянган төгрөг төсөвт буцаан татагдсанаас үзэхэд өр барагдуулахад нэмж олгосон 16620.8 мянган төгрөгийн төсвийн тодотгол хийлгэж, нэмэлт санхүүжилт авах шаардлагагүй байжээ.

Туслах аж ахуй

Аймгийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх ТАА-н зочид буудал, зоогийн газрын үйлчилгээ гэсэн 2 чиглэлийн үйл ажиллагаа явуулж ирсэн байна. 2013 оны байдлаар зочид буудлын үйлчилгээгээр 36873.5 мянган төгрөг, зоогийн газрын үйлчилгээгээр 107104.9 мянган төгрөгийн борлуулалтын орлого олжээ.

2013 онд нийт 146344.9 мянган төгрөгний орлого олж, 152249.7 мянган төгрөгний зардал гаргаж, 5904.7 мянган төгрөгний алдагдалтай ажилласан байна.

2013 оны Санхүүгийн тайлан

2. Үндсэн хөрөнгө

Аймгийн ЗДТГазар нь 2013 оны эхэнд 3239.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэй байсан ба тайлант онд 1034.4 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, 557.2 сая төгрөгийн хөрөнгө хасагдаж оны эцэст 3716.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна. Үүнд:

Барилга байгууламж дансанд Иргэний танхимын барилга 72905.9 мянган төгрөг, контейнер /морь барианы/ 14000.0 мянган төгрөг, морьны хашаа 2885.0 мянган төгрөг, 11-н орон сууц 555000.0 мянган төгрөг, ЗДТГазрын барилгын сайжруулалтад 11226.5 мянган төгрөг нийт 656017.5 мянган төгрөгийн хөрөнгө орлогоор бүртгэсэн байна. Уг дансанд бүртгэлтэй орон сууцнаас 9-н орон сууцыг 457840.0 мянган төгрөгөөр худалдах, 3-н орон сууцыг анхны өртөг 51489.7 мянган төгрөгнөөс бууруулан мянган төгрөгөөр хувьчилсан нийт 509329.7 мянган төгрөгийн хөрөнгийг данснаас хассан байна.

Автотээврийн хэрэгсэл дансанд Ланд крузер-200 авто машин 140.0 сая төгрөг, мөн Тоёота прадо-150 авто машин 2 ширхэг 196.0 сая төгрөг нийт 336.0 сая төгрөгөөр нэмэгдэж, хасагдсан хөрөнгө байхгүй байна.

Тоног төхөөрөмж дансанд Төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 4637.8 мянган төгрөгийн, бусад эх үүсвэрээр 15269.0 мянган төгрөгийн хөрөнгийг орлогоор бүртгэж, 35287.5 мянган төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хассан байна.

Тавилга эд хогшлын дансанд Төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 2596.4 мянган төгрөгийн, бусад эх үүсвэрээр 19831.6 мянган төгрөгийн хөрөнгийг орлогоор бүртгэж, 12610.4 мянган төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хассан байна.

Программ хангамж дансанд орлого, зарлага бүртгэгдээгүй байна.

Аудитаар 2013 оны жилийн эцсийн байдлаар аймгийн ЗДТГазрын барилга байгууламж дансанд 326367.1 мянган төгрөгийн үнэ бүхий 20 орон сууцны хаяг байршил, талбайн хэмжээ, эзэмшигч тодорхой бус ерөнхий нэрээр “орон сууц” гэж бүртгэсэн, хөрөнгө эзэмшигч бүрээр карт хөтлөөгүй зэрэг зөрчлүүдыг арилгах албан шаардлага бичлээ.

Данснаас хасагдсан хөрөнгөнд аймгийн ИТХурлын Тэргүүлэгчдийн 2013.10.15-ны өдрийн 95 дугаар тогтоол гарч аймгийн ЗДТГазраас 457840.0 мянган төгрөгний барилга байгууламжийг худалдахаар, 34880.6 мянган төгрөгний тоног төхөөрөмжийг актлахаар, 12665.1 мянган төгрөгний тавилга, хэрэгслийг актлахаар тус тус шийдвэрлэсэн боловч, барилга тогтоолд заасан хэмжээнээс 51489.7 мянган төгрөгөөр, тоног төхөөрөмж 406.9 мянган төгрөгөөр тус тус илүү, аж ахуйн тавилга, хэрэгсэл 54.7 мянган төгрөгөөр дутуу данснаас хасч, тогтоолын заалт зөрчигдсөн байна. Худалдсан 509329.7 мянган төгрөгний орон сууцны үнээс нэр бүхий 6 хүн 30-н хувийн урьдчилгаанд 92292.6 мянган төгрөгийг 140051002 тоот Хот байгуулалт, барилга алба дансанд төвлөхүүлж байгаад 2013- оны 12-р сард дээрх хүмүүсийн хувийн харилцах дансан буцаан шилжүүлсэн байна. Худалдсан орон сууцнуудын үнэ 457840.0 мянган төгрөгийг төвлөрүүлээгүй байхад орон сууцыг данснаас хассан мөн сууцны үнийг авлагаар тусгаагүй байна. Үндсэн хөрөнгийн элэгдэл өмнөх оныхоос 1059197.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгийн тооллогыг ЗДТГазрын даргын 2013 оны А/65 тоот тушаалаар томилогдсон тооллогын комисс 2013 оны 12-р сарын 17-с 12-р сарын 25- ний хооронд хийжээ. Тооллогын бүртгэлийг үндсэн тооцоог бодож, акт үйлдсэн байна. Тооллогоор дутагдсан, илүүдсэн хөрөнгө гараагүй байна.

2013 оны Санхүүгийн тайлан

Туслах аж ахуй

2013 оны эхэнд 96560.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгөтэй байсан ба 1540.6 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, 20897.7 мянган төгрөгийн хөрөнгө хасагдсан байна.

Тоног төхөөрөмжийн дансанд 1540.6 мянган төгрөгөөр нэмэгдэж 2669.3 мянган төгрөгийн хөрөнгө акталсан мөн тавилга хэрэгсэлээс 18228.4 мянган төгрөгийн хөрөнгө актлагдаж хасагдсан байна.

3.Бараа материал

2013 онд төсвийн хөрөнгөөр 92146.1 мянган төгрөгийн бараа, материал худалдан авч, үйл ажиллагаандаа 84998.1 мянган төгрөгний бараа, материал зарцуулж, 105.0 мянган төгрөгний бараа, материал бусдад худалдаж, 4183.3 мянган төгрөгийн бараа, материал актлаж данснаас хассан байна. Бараа, материалын үлдэгдэл оны эхэнд 4100.2 мянган төгрөг байсан бол оны эцэст 63092.1 мянган төгрөг болж, 2208.9 мянган төгрөгөөр буюу 53.9 хувиар өсчээ. Үүнд Бичиг хэргийн материал 653.6 мянган төгрөгөөр буюу 44.2 хувиар, Аж ахуйн материал 20814.4 мянган төгрөгөөр буюу 54.8 хувиар, сэлбэг 320.0 мянган төгрөгөөр буюу 5 дахин, шатах, тослох материал 300.9 мянган төгрөгөөр буюу 20.2 хувиар тус тус өсчээ.

Бараа, материалын орлого, зарлагын баримт, шаардах хуудасны хуулийн хүчинтэй байдлыг шалгахад, бараа материалыг олгосон, хүлээж авсан хүний гарын үсгийн бүрдэл дутуу, шаардах хуудсанд олгосон тоо, ширхэгийг тавиагүй зөрчил нилээд гарчээ. Бараа материал бэлтгэн нийлүүлэгчийн зарлагын баримтанд хүлээн авагчийн гарын үсэг зурагдаагүй тохиолдол нилээд байна. Бараа, материалын орлогын баримт /НХ маягт БМ-2/-ыг компьютерт оруулахдаа “шалгасан нягтлан бодогч” гэсэн хэсгийг орхигдуулснаас орлогын баримтанд шалгасан нягтлан бодогчийн гарын үсэг зурагдаагүй байна.

Нилээд тохиолдолд Анхан шатны баримтын нөхөлт дутуу, гарын үсгийн бүрдэл дутуу байгаа нь “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”-ийн 7.5. Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно.7.6. Анхан шатны баримтын бүрдэлт, үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна гэсэн хуулийн заалт зөрчигдсөн байна. Бичиг хэргийн материалаас 31.3 мянган төгрөгийн, аж ахуйн материалаас 4151.0 мянган төгрөгийн бараа материалыг актлаж, данснаас хасчээ.

Бараа материалын дансанд үлдэгдлээр тайлагнагдсан Биеийн тамирийн хувцасний үнэ 1045.0 мянган төгрөгийг ажиллагсадаас суутган авах акт бичив.

Туслах аж ахуй

2013 онд нийт 65684.5 мянган төгрөгний бараа, материал өөрийн хөрөнгөөр худалдан авч, 65308.6 мянган төгрөгний бараа, материал үйл ажиллагаандаа зарцуулж 19653.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. ТАА-н үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа зочид буудлын үнэт цаасны болон зоогийн газрын материалын тооцоог сар бүр бодсон байна.

4.Цалингийн талаар

2013 онд 631464.4 мянган төгрөгний цалингийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 588162.0 мянган төгрөгний цалингийн зардал гаргажээ. Батлагдсан цалингийн санг 43302.4 мянган төгрөгөөр хэмнэсэн байна.

Ажилтнуудын цалинг аймгийн ЗДТГазрын даргын 2012.3.23-ны өдрийн б/27 тоот тушаалаар тогтоож мөн оны 2 дугаар сарын 1-нээс мөрдсөн байгаа ба үүнээс хойш 2013 онд цалинг шинэчлэн тогтоогоогүй байна. Ажилтнуудын цалинг тогтоохдоо Засгийн газрын 2007

2013 оны Санхүүгийн тайлан

оны 354 дугаар тогтоолоор батлагдсан “Албан тушаалын ангилал, зэрэглэл, Засгийн газрын 2012 оны 78 дугаар тогтоолоор тогтоосон цалингийн сүлжээг баримтлан цалинг тогтоосон хэдий ч цалингийн шатлалыг тогтоох шалгуурыг ажлын үр дүнг бус ажилласан жилийг нь гол шалгуур болгон тогтоожээ. Мөн төрийн үйлчилгээний ажилтнуудад ур чадварын нэмэгдлийг нь шалгуур үзүүлэлтийг улирал бүр дүгнэн, нэмэгдлийг олгох эсэх, нэмэгдлийн хэмжээг тогтоох асуудлыг шийдвэрлэхгүйгээр тогтмол олгохоор уг тушаалд зааж, нэмэгдлийг олгож ирсэн байна.

Ажилтнуудын цалин хөлсийг тогтоохдоо “Төрийн албаны тухай хууль”-ийн 19.2. Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингийн үнэлгээг үндэслэн албан тушаал дэвшүүлэх, зохих шатны сургалтад хамруулах, цол, зэрэг дэв олгох, цалин хөлсийг өөрчлөх, шагнаж урамшуулах, албан тушаал бууруулах асуудлыг шийдвэрлэнэ. “Хөдөлмөрийн тухай хууль”-ийн 49.1. Ажилтны цалин хөлсийг хийснээр, цагаар, бусад хэлбэрээр хөдөлмөрийн үр дүнд нь тохируулан олгоно гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Төрийн үйлчилгээний ажилтнуудад ур чадварын нэмэгдлийн тогтмол нэмэгдэл байдлаар тогтоож, хавтгайруулан олгож ирсэн нь ХАБХ сайд, Сангийн сайдын 1996 оны 63/104 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Төрийн үйлчилгээний албаны түгээмэл мэргэжлийн албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”-ын 5-д ур чадварын нэмэгдлийг улирал бүр хэлэлцэн шийдвэрлэж байх, 6-д байгууллага нь ур чадварыг үнэлэх шалгуур үзүүлэлт, нэмэгдлийн хэмжээг тогтоосон журмыг боловсруулж, баталж мөрдөхөөр заасан заалт болон журмын 7-д Ур чадварын нэмэгдлийг ажилтнуудын цалинг нэмэх, амьдрал ахуйг харгалзах зэргээр хавтгайруулан олгохыг хориглоно гэсэн заалтыг зөрчсөн байна.

Мөн МУЗГазрын 2008.12.24-ны өдрийн 67 тоот тогтоолоор батлагдсан Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг шинэчлэн тогтоох тухай шийдвэр хүчингүй болоогүй бүтэц зохион байгуулалт нь өөрчлөгдөөгүй байхад Аймгийн ЗДТГазрын ХБХэлтсийн даргаар ажиллаж байсан Д.Чулуунбатад 4508.9 мянган төгрөгийн тэтгэмж үндэслэлгүйгээр олгож төсвийг зориулалт бусаар зарцуулсанд төлбөрийн акт бичив.

Туслах аж ахуй

Туслах аж ахуйн цалинг 53188.5 мянган төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 52967.8 мянган төгрөгийг зарцуулж 220.7 мянган төгрөгөөр хэмнэсэн байна.

5.Бараа үйлчилгээний зардал

2013 онд нийт 1041396.7 мянган төгрөгний төсөвт зардал батлагдсанаас 1002654.5 мянган төгрөгний зардал гаргаж (Эрх зүйн туслалцаа үзүүлэх төвийн 358.7 мянган төгрөг, Архивийн 50326.5 мянган төгрөгний зардлыг хассан дүнгээр), зардлыг нийт дүнгээр 38742.2 мянган төгрөгөөр дутуу зарцуулжээ. Дутуу зарцуулсан зардалд өндөр насны тэтгэвэрт гарах хүнд олгохоор батлагдсан 44179.8 мянган төгрөгнөөс 22973.1 мянган төгрөгийг 1 хүнд олгож, 21206.7 мянган төгрөг зарцуулагдаагүй, Архивийн санхүүжилтээс 3300.5 мянган төгрөг зарцуулагдаагүй, бусад төсвийн урсгал зардлаас 14235.0 мянган төгрөг тус тус зарцуулагдаагүй үлдсэн байна.

- Цалинд 631464.4 мянган төгрөгний төсөвт зардал батлагдсанаас гүйцэтгэлээр 588162.0 мянган төгрөгийн зардал гаргаж, батлагдсан төсвөөс 43302.4 мянган төгрөгний зарцуулагдаагүй үлдэгдэлтэй гарчээ.
- НДШимтгэлд 69461.0 мянган төгрөгний төсөв батлагдсанаас, 62919.5 мянган төгрөгний зардал гаргаж, 6541.5 мянган төгрөг зарцуулагдаагүй үлдсэн байна.

2013 оны Санхүүгийн тайлан

- Тогтмол зардалд 147014.4 мянган төгрөгний зардал батлагдсанаас 163635.2 мянган төгрөгний зардал гаргаж, батлагдсан зардлыг 16620.8 мянган төгрөгөөр хэтрүүлсэн байна. Үүнд: халаалтын зардал 15033.0 мянган төгрөгөөр, цахилгааны зардал 678.4 мянган төгрөгөөр, цэвэр усны зардал 909.3 мянган төгрөгөөр тус тус хэтэрч зарцуулагдажээ.
- Байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зардалд 68040.5 мянган төгрөг батлагдсанаас гүйцэтгэлээр 70220.5 мянган төгрөгний зардал гаргаж, батлагдсан зардлыг 20180.0 мянган төгрөгөөр хэтрүүлсэн байна. Хэтэрсэн зардалд шатахууны зардал 1040.9 мянган төгрөг, шуудан, холбооны зардал 1691.2 мянган төгрөгөөр хэтэрсэн нь гол байрыг эзэлж байна.
- Эд хогшлын зардалд 3160.0 мянган төгрөг батлагдсанаас 31063.1 мянган төгрөгний зардал гаргаж, батлагдсан зардлыг 27903.1 мянган төгрөгөөр хэтрүүлжээ. Хэтэрсэн зардалд аж ахуйн эд хогшил авсан 26850.7 мянган төгрөг гол нөлөөг үзүүлжээ.
- Томилолт зочны зардалд 29571.0 мянган төгрөгний зардал батлагдсанаас 24958.2 мянган төгрөгний зардал гаргаж, батлагдсан зардлыг 4612.8 мянган төгрөгөөр хэмнэсэн байна.
- Бусад бараа үйлчилгээний зардалд 48505.6 мянган төгрөгний зардал батлагдсанаас 38723.0 мянган төгрөгний зардал гаргаж, батлагдсан зардлыг 9782.6 мянган төгрөгөөр хэмнэсэн байна.

ЗДТГазар нь 2013 онд урьд оны төсвийн хэмнэлтийн зарцуулалт гэж 17307.0 мянган төгрөг зарцуулжээ. Үүнд : актын төлбөрт 11637.0 мянган төгрөг, бичиг хэрэг, хэвлэл, холбооны зардалд 169.4 мянган төгрөг, үндсэн хөрөнгө бэлтгэхэд 3876.4 мянган төгрөг, автомашины засварт 1624.2 мянган төгрөг зарцуулсан байна.

ЗДТГазрын дарга нь ЗДТГазрын “Хөдөлмөрийн дотоод журам”-ын заалтыг үндэслэн гэж 2013.5.24-нд а/36 тоот тушаал гарган ажилтнуудынхаа хүүхдүүдэд “Эх үрсийн баяр”-ын бэлэгэнд 1049.2 мянган төгрөг, 2013.03.06 –нд а/24 тоот тушаалаар Эмэгтэйчүүдийн баярт 1028.8 мянган төгрөг тус тус зарцуулах шийдвэр гаргаж 2078.0 мянган төгрөгийг ЗДТГазрын төсвөөс зарцуулсан байгаад төлбөрийн акт бичив.

Байгууллагын Хөдөлмөрийн дотоод журамд ажилчдынхаа хүүхдүүдэд бэлэг өгөхөөр тусгасан нь Хөдөлмөрийн тухай хуулийн 130.1. Ажил олгогч нь ажилтны төлөөлөгчдийн саналыг харгалзан хөдөлмөрийн дотоод журмыг хууль тогтоомжид нийцүүлэн баталж мөрдүүлнэ Төсвийн тухай хуулийн 6.4.1-д заасан “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” 16.5.5.батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, 41.2.2.батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах гэсэн заалтуудтай нийцэхгүй заалт Хөдөлмөрийн дотоод журамдаа оруулж, хуулийн заалт зөрчигдсөн байна.

Төсвөөс урамшууллыг олгосон, түүнийг захиран зарцуулсан байдал нь “Төсвийн тухай хууль”-ийн 46.3.Энэ хуулийн 46.1-д заасан урамшууллыг хэрхэн зарцуулах асуудлыг байгууллагын нийт ажилтныг оролцуулсан хамт олны хурлаар хэлэлцэн, түүнийг үндэслэн шийдвэрлэх бөгөөд уг хурлын тэмдэглэл болон шийдвэрийн хувийг тухайн шатны төрийн санд хүргүүлэх ба түүнийг үндэслэн урамшууллыг зарцуулах эрхийг олгоно. 46.4.Төсвийн урамшууллыг энэ хуулийн 44.5-д заасан арга хэмжээ болон байгууллагын хамт олныг ажлын үр дүнг нь харгалзан урамшуулах, нийт ажилтны нийгмийн асуудлыг шийдвэрлэх зэрэг нийтлэг арга хэмжээнд зарцуулна гэсэн заалтыг зөрчиж хууль тогтоомж зөрчсөний улмаас эрх бүхий байгууллагаас тогтоосон актын төлбөр болон төсвийн урсгал зардалд батлагдсан төсвийг хэтрүүлэн зарцуулсан төсвийн урсгал зардлын эх үүсвэр болгон ашигласан зөрчил гаргасан байна.

2013 оны Санхүүгийн тайлан

Батлагдсан төсөвт зардлыг зөвшөөрөгдсөн бүлгээс бүлэгт шилжүүлэн зарцуулахдаа Төсвийн тухай хуулийн 42-р зүйл, Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”-ын дагуу гүйцэтгэж, ТЗБ-№1 маягтаар баталгаажуулж авч байх ... гэсэн хууль, журмын заалтыг хэрэгжүүлж ажиллах.

Албан томилолтын зардлын баримтыг шалгахад гүйцэтгэх ажлын удирдамжийг тодорхой бичдэггүй, гүйцэтгэлийн нэг бүрчлэн гаргадаггүй зөрчил байна. Жишээ нь 2013.1.8-нд ХШҮТ-ийн ахлах шинжээч Б.Бадамжав нь Дэлгэрхаан, Бүрэн, Өндөрширээт сумдад ажиллахаар 3 хоногийн Албан томилолтоор ажиллах ажлынхаа удирдамжийн гүйцэтгэх ажлын удирдамж гэсэн хэсэгт **Бүрэн, Дэлгэрхаан суманд ажиллах** гэж бичсэн, гүйцэтгэсэн ажлын тайланд **Бүрэн, Дэлгэрхаан сумдад 1- сарын .../өдрийг бөглөөгүй/ 1-р сарын 12-ний өдрүүдэд цаг үеийн ажлаар ажиллав** гэж тайлагнажээ. Удирдамжийг ЗДТГазрын дарга **батлаагүй** байгаа боловч 3 хоногийн хугацаагаар Бүрэн, Дэлгэрхаан суманд ажиллах албан томилолт олгож, ажлынх нь гүйцэтгэлийг дүгнэж, томилолтын зардлыг 100 хувь олгохыг зөвшөөрсөн цохолт хийсэн байна. Б.Бадамжав нь энэ томилолтоор ажиллахдаа **удирдамжинд заагдаагүй Өндөрширээт суманд 1 сарын 10-наас 1 сарын 12-нд ажилласнаар томилолтын үнэмлэхэнд тэмдэглүүлж, 2 хоногийн зам хоногийн зардалд 24000 төгрөг** авчээ.

Мөн аймгийн Засаг даргын орлогч Ш.Төмөрчөдөрийг 2013.5.26-ний өдөр 1000 малчныг алдаршуулах арга хэмжээг зохион байгуулахаар сумдад албан томилолтоор ажиллахад нь Албан томилолтын удирдамжийг нь ЗДТГазрын дарга баталж, томилолт олгож, ажлыг нь дүгнэжээ. Засаг даргын орлогч Ш.Төмөрчөдөр нь Томилолтоор гүйцэтгэсэн ажлынхаа тайланг бичээгүй байна. Мөн хамт томилолтоор ажилласан ТЗУХэлтсийн дарга С.Цогбаяр гүйцэтгэсэн ажлынхаа тайлан бичээгүй байна.

2013 оны 2 дугаар сарын 8-ний өдөр “Аймгийн ЗДТГ-ын Техникийн дүгнэлт шинжээчийн комиссын акт “ гэсэн баримтанд “Аймгийн ЗДТГ-ын техникийн дүгнэлт шинжээчийн комиссын гишүүд Д.Чинзориг, Б.Одончимэг, Н.Эрдэнэболд, Ч.Пүрвээ бид нар *ЗДТ-ын газрын ТӨА 00-06 дугаартай машиныг /харлуулсан хэсгийг гараар бичжээ/ шалгаж үзээд доорх дүгнэлт, акт тогтоов. Үүнд : Нэг. Тормозны хойд наклад-2 ш /ком/, урд наклад-2 ш /ком / гэжээ. Маягтын 2 гэсэн хэсэг бөглөгдөөгүй, Шийдвэрлэсэн нь : бөглөгдөөгүй. 4 гишүүд бүгд гарын үсгээ зуржээ. Энэ дүгнэлт, акт гэсэн баримт бичиг юу гэж дүгнээд байгаа, ямар утгатай акт гараад байгаа нь ойлгомжгүй болжээ. /Зүй нь наклад элэгдэж техникийн бүрэн бүтэн байдал алдагдсан уу. Энэ наклад тавиад хэдэн км явсан, солих шаардлагатай эсэхэд л дүгнэлт гаргах байжээ/*

Туслах аж ахуй

Борлуулалтанд ногдох зардлыг зочид буудал, зоогийн газар гэж ялгаж тайлагнаагүй, борлуулалтын ашгаас санхүүжих удирдлагын зардлыг мөн тусгайлан харуулалгүй нийтэд нь төсвийн зардлын зүйлээр ангилан харуулсан байна. Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар бараа, үйлчилгээний урсгал зардалд 2013 онд 55345.1 мянган төгрөгний зардал гаргахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 83451.4 мянган төгрөгний зардал гаргаж, төлөвлөсөн зардлыг 28106.3 мянган төгрөгөөр хэтрүүлжээ. Энэ дүнд жилийн эцэст татан төвлөрүүлсэн үлдэгдэл 13096.0 мянган төгрөг орсон ба үүнийг хасаж тооцвол 15010.0 мянган төгрөгөөр зардал хэтэрсэн ба энэ нь хоолны зардал байна.

2013 оны Санхүүгийн тайлан

6. Мөнгөн хөрөнгө

2013 онд харилцах дансны мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 18976.6 мянган төгрөг байна. Харилцах дансаар нийт 1127289.0 мянган төгрөгний орлогын гүйлгээ, 1125059.0 мянган төгрөгний зарлагын гүйлгээ хийгдэж, оны эцэст харилцах дансанд 21206.7 мянган төгрөгний үлдэгдэлтэй байна.

Энэ үлдэгдэл нь өндөр насны тэтгэвэрт гарсан хүнд олгох тэтгэмжийн батлагдсан төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл байна. Харилцах дансны орлого, зарлагын гүйлгээний анхан шатны баримт, холбогдох эрхийн акт, гэрээ зэрэг гүйлгээг нотлох баримтын бүрдэл сайтай байна.

ЗДТГазрын кассаар 2013 онд харилцах данснаас 28157.8 мянган төгрөгний орлого авч, мөн хэмжээний зардал гаргажээ. Касст орлого авахдаа “Бэлэн мөнгөний хүсэлт” бичиж Төрийн сан дахь харилцах данснаас касст мөнгө гаргасан байгаа ба касст кассын орлого бичиж уг мөнгийг хүлээж авчээ. Касснаас зарлага гаргахдаа “Мөнгө олгохыг хүссэн өргөдөл”-ийг холбогдох хүмүүсээр бичүүлж, 1,2-р гарын үсгийн бүрдэлтэй “Кассын зарлагын баримт”-аар касснаас зарцуулалт хийсэн байна. Мөнгө олгохыг хүссэн өргөдөлд 2-р гарын үсгийн цохолт хийхгүй байгаа дутагдал байна.

Касснаас бэлэн мөнгө авч явж харилцагчид төлбөр хийсэн хүмүүс мөнгө хүлээж авсан байгууллагын касст мөнгө тушаасан “Кассын орлогын баримт”-ын хувийг санхүүд өгч дараа тайлангийн тооцоо хийгээгүй зөрчил байна. Жишээ нь Эрдэнэболд Төв аймгийн сервер байршиж байгаа Үндэсний Дата төвд жилийн лицензийн төлбөрт төлсөн 591600 төгрөгийг тус төвд бэлнээр төлөхдөө мөнгө тушаасан “Кассын орлогын баримт”-ыг тус төвөөс авч, санхүүд өгч дараа тайлангийн тооцоо хийгээгүй байна.

Харилцах дансны үлдэгдлийн баталгааг Маягт № ТТ-6-аар жилээр гаргаж, Төрийн сангаар баталгаажуулаагүй байна.

Засгийн газрын 2013 оны 287 дугаар тогтоолоор баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын заалтыг хэрэгжүүлж, дансны үлдэгдлийн баталгааг жилээр гаргаж, Төрийн сангаар баталгаажуулж, санхүүгийн баримтанд 12 сарын дансны хуулганд хавсаргаж байх.

Кассын үйл ажиллагаанд Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагад мөрдөгдөх мөнгөн кассын ажиллагааны журам”-ыг мөрдлөгө болгож ажиллах.

7. Авлага, өглөгийн талаар

Аудитын төлөвлөгөөнд тусгагдсан биет сорилыг гүйцэтгэхэд:

Санхүүгийн тайланд оны эхэнд өглөггүй оны эцэст 23.2 мянган төгрөгний өглөгтэй гарчээ. Авлага оны эхэнд 611.3 мянган төгрөг байсан бол оны эцэст 511.2 мянган төгрөг болж, авлага 100.0 мянган төгрөгөөр буурчээ.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”-ийн 9.1. Аж ахуйн нэгж, байгууллага нь хөрөнгө, өр төлбөрөө нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэлж дансанд тусгана гэсэн заалтыг хэрэгжүүлж, өглөг, авлагаа дансанд бүрэн тусгаж байх.

Туслах аж ахуй

2013 оны эхэнд бусдаас авах авлага 2930.7 мянган төгрөг, оны эцэст 3375.8 мянган төгрөг болж, авлага 445.1 мянган төгрөгөөр буюу 15-н хувиар өссөн байна. Авлагыг байгууллагаар задлавал МАНХороо 1534.9 мянган төгрөг, Зуунмод ЭХСалбар 275,5 мянган төгрөг, ХААН банк 59.2 мянган төгрөг, НДХэлтэс 169.8 мянган төгрөг, ЭМГазар 169.3 мянган төгрөг, ТАЗГазар 44.7 мянган төгрөг, МСҮТ 25.0 мянган төгрөг, БОАЖГазар 133.0 мянган төгрөг,

2013 оны Санхүүгийн тайлан

ХЭКомисс 147.3 мянган төгрөг, Цагдаагийн газар 15.3 мянган төгрөг, Хөдөлмөрийн хэлтэс 190.0 мянган төгрөг, БСГазар 35.0 мянган төгрөг, ажиллагсад 576.8 мянган төгрөг нийт 3375.8 мянган төгрөгийн авлага байна. Аудитын хугацаанд дээрх авлагаас 464.6 мянган төгрөгийн авлагыг барагдуулсан ба ЗДТГазрын ТАА-н үйл ажиллагаанд өөрчлөлт орж түрээсээр ажиллуулах болсонтой холбогдуулан авлагын үлдэгдэл 2911.2 мянган төгрөгийг барагдуулах төлбөрийн акт бичив. Өглөг 117.3 мянган төгрөг ба энэ нь цалингийн өглөг байсаныг аудитын явцад барагдуулсан байна..

48. Дотоод хяналт шалгалтын талаар

2013 онд аймгийн ЗДТГазар нь дотоод хяналтын комисс томилоогүй, төлөвлөгөө боловсруулж батлуулаагүй санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгээгүй байна.

Бидний дахин шалгалтын үр дүнд дээр дурдсан 8 хэсгүүдийн дотоод хяналтын ситем нь тухайн жилд хангалттай байсан ба нягтлан бодох бүртгэл нь Санхүүгийн тайлангийн зохистой үндэс болсон нь ажиглагдсан юм. Сайжруулах шаардлагатай байж болох хэд хэдэн санхүүгийн хяналтын талаар хавсралт бүхий удирдлагын захидалд тусгасан болно.

Аудитын явцад хийгдсэн гол шийдлүүд

5. Дараах хэсэгт Санхүүгийн тайлангийн аудит явцад гарсан гол асуудлуудыг хураангуйлан тэмдэглэсэн.

- ✓ Байгууллагын зардлын гүйцэтгэлийг бодитой бус тайлагнах нь төсвийн төлөвлөгөөг хийх, хянах, батлах, шинжилгээ судалгааны дүнд нөлөөлөх тул зардлыг үнэн зөв тайлагнаж байх

6. Бидний илрүүлсэн зүйлс болон дээрх санхүүгийн дотоод хяналтын талаар санал нь удирдлагын захидалд тусгагдсан байна. Санхүүгийн гүйлгээнүүд нь хүлээн зөвшөөрхүйц зохицуулагдсаныг тэмдэглэсэн.

Залруулагдаагүй алдаа

7. Аудитын стандарт нь ААГ-г аудитын явцад илэрсэн тодорхой биш болон залруулагдаагүй алдаанд анхаарал тавихыг шаарддаг. Аудитын явцад Үр дүнгийн тайланд хандиваар болон үнэ төлбөргүй авсан хөрөнгийн орлого болох 1034783.7 мянган төгрөгийн алдааг залруулсан болно.

Тайлбар мэдүүлгийн захидал

8. Аудитын үйл явцад ААГ хөндлөнгийн аудиторын хувьд удирдлагын зүгээс гаргасан баталгаанд тулгуурлах ёстой байсан ч хараат бус байдлын хувьд энэ батламжийг дагах нь зохистой байсангүй. Аудитын гүйцэтгэл бүрд /тайлбар мэдүүлгийн захидлаар/ ЕМ-ээс эдгээр баталгааг бичгээр авсан байна.

Өмнөх зөвлөмжийн биелэлт

2012 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах 4 зөвлөмж өгөгдсөнөөс

- Манзуширын үйлчилгээний өмнөх оны түрээсийн төлбөрийг барагдуулж шийдвэрлэх

2013 оны Санхүүгийн тайлан

- ЗДТамгын газрын хөрөнгөнд бүртгэлтэй Албан тушаалын орон сууцыг хаяг байршил оршин суугчдыг тодорхой болгож, үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээг эх хувиар хадгалах

гэсэн зөвлөмжүүдийг хэрэгжүүлээгүй байна.

Аудитын санал дүгнэлт

Аймгийн Аудитын газраас аймгийн ЗДТГазрын 2013 оны санхүүгийн тайланд зөрчилгүй санал дүгнэлт гаргахаар санал оруулж байна.